

БАТЛАВ.

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГАЗРЫН
ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА

Д.ГАНБАЯР

2019 оны 03 сарын 25-ны өдөр

**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
2019 ОНЫ АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ, ШУДАРГА ЁС, ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Д/ д	Хийх ажил	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт		Хариуцах эзэн
			Хугацаа	Гүйцэтгэлийн үзүүлэлт	
Зорилт 1. Шударга байдал, ёс зүйн хэм хэмжээг дээшлүүлэх					
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчлах, сургалт зохион байгуулах	1. Авлигатай тэмцэх газар, АЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэстэй хамтран сургалт зохион байгуулах 2. Эрх бүхий албан тушаалтнуудын сургалтыг зохион байгуулсан үед хамрагдах	Харас, бүтэн жилдээ Тухайн үед нь	2 удаа Зохион байгуулсан тоогоор	Хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн Хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн
2	ГХБХБГ газарт "Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрэм"-ийг мөрдүүлэх	1. "Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрэм"-ийг зөрчсөн тухай мэдээллийг санал хүсэлтийн хайрцгаар хүлээн авах 2. Зөрчлийн талаар бүртгэлийг хөтлөн, хуулийн хугацаанд шийдвэрлэх, хариуцлага тооцох, ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй тохиолдолд урьдчилан сэргийлэх зөвлөмж өгч ажиллах	Жилдээ	Өргөдөл гомдол хүлээн авах үйл ажиллагаа түргэн шуурхай, байнгын тогтвортой ажиллах Хуулийн хугацаанд шийдвэрлэн, хариуцлага тооцсон, зөвлөгөө өгсөн байх	Газрын дарга, Хэлтсийн дарга нар, Хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн Хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн
Зорилт 2. Авлигыг үүсгэж болзошгүй дүрэм журмыг хянах, хариуцлагын тогтолцоо бий болгох					
3	Давхар ажил эрхлэлтийг шийдвэрлэх	1. Хууль болон Засгийн газраас зөвшөөрсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргаж нийт албан хаагчдад танилцуулах 2. Албан хаагчдын давхар ажил эрхлэлтийн судалгааг гаргуулан авч, нэгдсэн журмаар давхар ажил эрхлэх зөвшөөрөл олгох, хуулиар хориглосон давхар ажил эрхлэлтийн асуудлыг зохицуулах, үүрэг чиглэл өгөх	Жилдээ	Журмын хүрээнд хийгдсэн байх Давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалтыг хэрэгжүүлэх журмын хүрээнд хийгдсэн байх	Хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн Газрын дарга, Хэлтсийн дарга нар, Хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн
4	Авлигын эрсдэл ба авлига гарах	1. Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний	Жилдээ	Авлигын эсрэг хуулийн хүрээнд	Хэлтсийн дарга нар, Хуулийн

	боломжийг бууруулах	жагсаалтыг тодорхой судалгаа, шинжилгээнд тулгуурлан гаргах		хийгдсэн байх	асуудал хариуцсан мэргэжилтэн
		2.Эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээг гүйцэтгэж буй албан тушаалтаны үйл ажиллагаанд хяналт тавих нөхцлийг бүрдүүлэх, бичгээр зөвлөмж өгөх	Жилдээ	Авлигын эсрэг хуулийн хүрээнд хийгдсэн байх	Хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн
5	Иргэдийн өргөдөл, гомдол хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах	1.ГХБХБГазрын чиг үүрэг, эрхлэх асуудлын хүрээг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх, сурталчилах	Жилдээ	Авлигын эсрэг хууль, Мэдээллийн ил тод байдал мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хүрээнд хийгдсэн байх	Газрын дарга, хэлтсийн дарга нар
		2.ГХБХБГ-ын www.darkhan.gazar.gov.mn сайт, 70376483 утас, санал хүсэлтийн хайрцгаар өргөдөл, гомдол, санал хүсэлт, мэдээлэл хүлээн авах	Жилдээ		
		3.Өргөдөл, гомдол хариуцсан мэргэжилтнүүдийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утасны дугаар, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг www.darkhan.gazar.gov.mn Цахим хуудсанд болон ГХБХБГ-ын мэдээллийн самбарт байршуулах	Тухай бүр	Авлигын эсрэг хууль, Мэдээллийн ил тод байдал мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хүрээнд хийгдсэн байх	Газрын дарга, хэлтэсийн дарга нар
Зорилт 3. Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллах					
6	1.АТГ-ын цахим хуудсанд үнэлгээ хийх аргачлалын дагуу Дархан-Уул аймгийн www.darkhan.gazar.gov.mn сайтыг шинэчлэн сайжруулах, холбогдох мэдээллийг оруулах	1.Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын www.darkhan.gazar.gov.mn сайтын мэдээллийг байнга шинэчлэн сайжруулах	Өдөр тутам	АТГ-аас тавьж буй шаардлагын хэмжээнд байх	Мэдээлэл технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн
		2.Шаардлагатай мэдээллийг ажилтнууд байнга гаргаж өгөх	Улирал тутам	Цаг хугацаанд нь файл болон цаасан хэлбэрээр өгсөн байх	Хэлтсийн дарга нар, Мэдээлэл технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн
7	Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах	1.Сул орон тооны зар, сонгон шалгаруулалт явуулах дүрэм журам, бүрдүүлэх материал, төлбөр хураамж, холбогдох бусад мэдээллийг ГХБХБГ-ын www.darkhan.gazar.gov.mn цахим хуудас мэдээллийн самбарт байршуулах, тухай бүр шинэчлэх	Жилдээ	Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5, Мэдээллийн ил тод байдлал, мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн хүрээнд хийгдсэн байх	Хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн
		2.Сонгон шалгаруулалт			

		явуулах талаар тухай бүр олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах,	Тухай бүр		асуудал хариуцсан мэргэжилтэн
		3.Сонгон шалгаруулалтын явуулсан тайлан, сонгон шалгаруулалтад тэнцсэн болон тэнцээгүй иргэдийн тухай мэдээллийг www.darkhan.gazar.gov.mn сайтад ГХБХБГ-ын мэдээллийн самбар, хэвлэл мэдээллийн түгээх	Тухай бүр		Хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн
8	3.Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаад зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх	1.Тухайн жилийн төсөв, өмнөх оны төсвийн гүйцэтгэл, дараа жилийн төсвийн төслийг www.darkhan.gazar.gov.mn цахим хуудсанд байршуулах	4 сарын 1-ний дотор, 8 сарын 15-ны дотор	Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4, Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн хүрээнд хэрэгжүүлсэн байх	Ахлах нягтлан бодогч
		2.Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь www.darkhan.gazar.gov.mn цахим хуудсанд болон ГХБХБГ-ын мэдээллийн самбарт байршуулна.	Тухай бүр		Ахлах нягтлан бодогч
		3.Төсвийн орлого /газрын төлбөрийн орлого/ бүрдүүлэлтийн талаархи мэдээллийг дээрх хэлбэрээр сурталчилах	Тухай бүр		Газрын татвар, төлбөр, үнэлгээний асуудал хариуцсан мэргэжилтэн, Ахлах нягтлан бодогч
		4.Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээд /ГХБХБГ-ын албан хаагч/-ийн жагсаалтыг гаргаж дээрх хэлбэрээр байршуулах, тухай бүр шинэчлэх	Тухай бүр		Ахлах нягтлан бодогч
Зорилт 4. Авлигын эсрэг хууль тогтоомж, төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах					
9	Авлигатай тэмцэх, шударга ёс ил тод байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих	Төлөвлөгөө болон түүний хэрэгжилтийг байгууллагын нийт ажилтнуудад танилцуулах	Хагас, бүтэн жил	Нийт албан хаагч нарт танилцуулсан байх	Хэлтсийн дарга нар, Хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн
10	Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг	1.Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ	Жилдээ	Ашиг сонирхлыг зөрчлөөс урьдчилан сэргийлэх	Хуулийн

сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах	илэрхийлсэн мэдэгдлийг зохих журмын дагуу авах, бүртгэх, хянах шалгах		зорилгоор хийгдсэн байх	асуудал хариуцсан мэргэжилтэн
	2.Албан тушаалтнуудын ХАСХОМ-ыг хүлээн авах, бүртгэл хөтлөх зөвлөгөө өгөх, хяналт тавих, хадгалах, мэдээлэл өгөх	Жилдээ	АТГ-ын даргын тушаалаар батлагдсан журмын хүрээнд хийгдсэн байх	Хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн
	3.Хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг гаргуулан авч холбогдох материалын хамт АТГ-т хүргүүлэх, бүртгэл хөтлөх	Жилдээ	АТГ-ын даргын тушаалаар батлагдсан журмын хүрээнд хийгдсэн байх	Хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн
	4.АТГ-ын Мэдүүлгийн бүрдүүлэлтийн програмд ХАСХОМ бусад мэдэгдэл, мэдүүлэгийг бүртгэх, шивж оруулах	Жилдээ	АТГ-ын даргын тушаалаар батлагдсан журмын хүрээнд хийгдсэн байх	Хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн
	5.АТГ-т Мэдүүлгийн бүрдүүлэлтийн тайланг гаргаж хүргүүлэх	2 сарын 15-ний дотор	Хууль тогтоомжийн хүрээнд хийгдсэн байх	Хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Төлөвлөгөө гаргасан:

ЭБАТ:  Ч.Анхбаяр

2019 оны 03 дугаар сарын 25-ны өдөр